



ТӨВ АЙМГИЙН МОНГОЛ ТУУРГАТАН ТЕАТРЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Төв аймгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70272582
И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com
Факс: 01-272-22582

Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273465
И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Аудитор: Г.Бадар-Ууган
Утас: 70273463
И-мэйл: gaagii_777@yahoo.com

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Аудитын газрын хаяг:
Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

2015 оны 03 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Монгол туургатан театрын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2014/110/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Монгол туургатан театрын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Монгол туургатан театрын 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 03 дугаар сарын 21-наас 2015 оны 03 дугаар сарын 25-ныг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн гишүүн аудитор Г.Бадар-Ууган хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Монгол туургатан театрын 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 02 дугаар сарын 25-нд Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймгийн Аудитын газар аудитыг 2015 оны 03 дугаар сарын 21-наас 2015 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 03 дугаар сарын 25-нд Төв аймгийн Монгол туургатан театрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Үндэсний болон дэлхийн соёл урлагийн бүтээлүүдээр урын сангаа баяжуулж, хүн амд үйлчлэн, урлаг соёлын үйлчилгээг чанартай хүргэх зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Соёлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж зэргийг дагаж мөрдөнө.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38 –д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг гэж заасны Төв аймгийн Монгол туургатан театрын дарга Төв аймгийн Монгол туургатан театрын төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн ИТХ-аас баталж Аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хяналт шинжилгээний тухай хууль, төсвийн тухай хуулиуд бүрэн хэрэгжиж, Төсвийн тухай хуулийн 16.5. Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийн 16.5.6-д дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Монгол туургатан театрын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар 7 аудитын хяналтын горим, нарийвчилсан 13 сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаагүй байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн ИТХ-аас төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваариалан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төв аймгийн Монгол туургатан театр нь 2014 онд төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 570033.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 13470.3 мянган төгрөгийн орлого олжээ. Үүнээс урсгал зардалд 581516.0 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1988.2 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 19 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 6, нарийвчилсан 22, горим сорил гүйцэтгэв.

Үр дагавар Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төв аймгийн Монгол туургатан театрын 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 500.0 мянган төгрөгөөс дээш дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 93.0 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний 22892.5 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Төв аймгийн Монгол туургатан театр нь 2014 онд үндсэн үйл ажиллагааны орлогоор 34212.5 мянган төгрөгийн орлого олох ёстойгоос гүйцэтгэлээр 13320.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж өөрийн орлогын төлөвлөгөөг 20892.5 мянган төгрөгөөр тасалсан байна. Тус орлогыг театрын тоглолтын хувцасны түрээс, заалны түрээсийн орлогоор бүрдүүлсэн байна. Нийгмийн даатгалын хэлтсээс листний олговорт 150.3 мянган төгрөгийг андуурч орж ирсэнийг залруулах гүйлгээ хийгээгүй өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнасан байна.
2. Дотоод албан томилолтын зардыг олгохдоо албан томилолтын хуудсыг томилсон байгууллагын удирдлагаар хянуулж гарын үсэг зуруулаагүй байна.

Шийдвэрлэсэн: Байгууллагын удирдлагаар хянуулж баталгаажуулаагүй олгосон 200.0 мянган төгрөгийн зөрчил акт бичив.

3. ССАЖГазраас үзвэрийн үнэнд бэлнээр тушаасан 1800.0 мянган төгрөгийн орлогыг данс бүртгэлд тусгаагүй.

Шийдвэрлэсэн: Өөрийн орлогоор төвлөрүүлж данс бүртгэлд тусгаагүй 1800.0 мянган төгрөгт акт бичив.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно. Материаллаг бус 12977.5 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг бичиг хэргийн зардалд бүртгэж орлого авсан байна.

1. Бараа материалын орлого, зарлагын журналыг сортлон хөрөнгийн бүртгэлийг зөв ангилсан эсэхийг тулган шалгахад бичиг хэргийн материалд Буриадын соёл спортын хороо ТББ-тай гэрээ байгуулж "Аадар" жүжгийн зохиол бичүүлэх төлбөрт 12977.5 мянган төгрөгийг шилжүүлснийг бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн: НББ-ийн бодлогын баримт бичигт заасны дагуу бичиг хэргийн материалын дансанд бүртгэсэн жүжгийн зохиолыг биет бус хөрөнгөөр бүртгэж тайлагнах албан шаардлага бичив.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Төв аймгийн МТТеатр нь тайлант онд “Би амьдармааргүй байна” “Аадар” зэрэг жүжгийн тайз засал, жүжгийн зохиол, хувцасны зардал зэрэгт нийт 24085.5 мянган төгрөгийн зардал гаргасан боловч тайлант онд тус жүжгүүдээр орлого олоогүй байна. Өөрийн орлогын төлөвлөгөөгөөр 34212.5 мянган төгрөг төлөвлөгдсөн боловч 2014 онд нийт 13320.0 мянган төгрөгийн орлого оруулж өөрийн орлогын төлөвлөгөөг 20892.5 мянган төгрөгөөр тасалсан байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох ажилчдын цалингаас суутгасан суутгалууд нь үзэхэд хүндрэлтэй байсан ба цалингийн цэснээс ажилчдаас нийт 26968.4 мянган төгрөгийн суутгал хийсэн боловч ямар шалтгаанаар суутгасан нь тодорхойгүй тайланд тусгасан авлагатай зөрүүтэй асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Монгол туургатан театрын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 14977.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 2000.0 мянган төгрөгийн зөрчилд акт бичиж, 12977.5 мянган төгрөгийн албан шаардлага бичигдэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Монгол туургатан театрын төсвийн 2013 оны санхүүгийн тайланд аудит хийж 3 зөвлөмж өгөгдсөн ба хэрэгжилийн хариуг албан бичгээр Төв аймгийн Аудитын газарт заасан хугацаанд ирүүлээгүй байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол туургатан театрын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР**

**Л.ЖАРГАЛСАЙХАН
О.АМАРЖАРГАЛ**

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Г.БАДАР-УУГАН

Огноо: 2015.03.17